

БНХАУ-ЫН ШУА-ЫН ДЭРГЭДЭХ ШИНЖААНЫ ЭКОЛОГИ, ГАЗАРЗҮЙН ХҮРЭЭЛЭНГЭЭС ЗОХИОН БАЙГУУЛЖ БУЙ ТАКЛАМАКАНЫ ЦӨЛИЙН ГУРАВДУГААР ФОРУМ БОЛЖ ӨНГӨРЛӨӨ

Хятадын Шинжаан, Уйгурын өөртөө засах оронд болж өнгөрсөн “Такламаканы цөлийн гуравдугаар форум”-д Африк, Төв Ази, Зүүн Хойд Азийн 30 гаруй эрдэмтэн, судлаачид, албаны хүмүүс оролцов. Зохион байгуулагчдын урилгаар Газарзүй, Геоэкологийн Хүрээлэнгийн ЭШТА, доктор (Ph.D) А.Хауланбек, ЭШДада Б.Оюундарь нар тус форумд оролцож ирээд байна. Тус форум нь 2023 оны 06 сарын 07-оос 2023 оны 06 сарын 18-ны хооронд болсон бөгөөд эхний өдрүүдэд олон улсын эрдэмтэн, судлаачид харилцан туршлага хуваалцах, санал солилцох зэрэг форумын үндсэн үйл ажиллагаа явагдсан бөгөөд ЭШТА, доктор (Ph.D), А.Хауланбек “Монгол орны цөлжилт, газрын доройтолтой тэмцсэн туршлага” сэдэвт илтгэл хэлэлцүүлэв. Мөн дугуй ширээний ярилцлага өрнүүлж, Монгол орны цөлжилтийн өнөөгийн байдал, хийгдэж буй ажил, улсын хэмжээнд хэрэгжиж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний талаар хэлэлцүүлэг хийв. Форумын хоёр дахь өдөр ЭШТА, доктор (Ph.D), А.Хауланбек Хятадын CCTV телевизийн редакцад Такламаканы цөлийн гуравдугаар форумын ач холбогдол, Монгол орны туршлага зэрэг сэдвээр ярилцлага өгсөн байна.



Энэхүү форумын үеэр олон улсын эрдэмтэн, судлаачид харилцан туршлага судлан, санал солилцсон ба Хятадын цөлжилттэй тэмцэх шинэ технологиуд, Узбекистан улсын Арал далайг хамгаалах үйл хэрэг зэрэг нь судлаачдын анхаарлыг ихээхэн татаж байлаа.

Хурлын зочид төлөөлөгчид Корла хотоос эхлээд Хотан хот хүртэл буюу Такламаканы цөлийн умард хэсгээс өмнөд хэсэг хүртэл 552 км замыг туулж, Такламаканы цөлд хийгдсэн цөлжилттэй тэмцэх технологиуд, ойн зурвас, элсний механик хамгаалалт, судалгааны төвүүд, ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн үйл ажиллагаатай танилцан, туршлага судлах аялал хийв.

Такламаканы цөлийн зам нь анх газрын тос тээвэрлэх зориулалтаар баригдсан ба замыг хамгаалахын тулд механик хамгаалалт болон ойн зурвасыг 500 гаран км газарт байгуулсан байна. Нарны толь ашиглан сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэн, гүний худгаас ус татаж усжуулалтын шийдвэрлэсэн ба нийтдээ 130 гаруй гүний худгийг ашигладаг байна. Мөн механик хамгаалалтын технологийг сайжруулах туршилт судалгаанууд

эрчимтэй хийгдэж байсны нэг нь ургамлын гаралтай, 10 жилийн настай, +70 градуст тэсвэртэй материалыг гарган авч туршсан явдал байлаа.



Такламаканы цөл дэх Турпаны Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн (Turpan Eremophytes Botanical Garden, CAS) нь 1976 онд байгуулагдсан бөгөөд *Tamarix*, *Calligonum* зэрэг нийт 600 гаруй зүйлийн ургамлын цуглуулгатай байна.

Цааш Хотан хот дахь Хятадын ШУА-ын Шинжааны Экологи, Газарзүйн хүрээлэнгийн дэргэдэх улсын зэрэглэлийн Села суурин судалгааны төв (*Cele Desert Research Station*)-ийн үйл ажиллагаатай танилцсан. Энэхүү судалгааны төв нь элсний нүүдлээс үүдэн доройтож буй экосистем болон тухайн нутаг дахь амьтдыг хамгаалах зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулдаг ба бид ургамлын үндэсний системийн судалгаа, элсний нүүдэл, шороон шуургыг ажиглах цамхаг, музей, ургамал тарьж, ургуулснаар бий болох хөрсний органик нэгдлийн өөрчлөлтийг хэмжих зэрэг судалгааны ажлын үйл явцыг танилцуулав. Туршлага судлах аяллын сүүлийн өдөр Хятадын эрдэмтэд, аж ахуйн нэгжийн хамтран хэрэгжүүлж буй ашигт эмийн ургамал болох гоёог тарималжуулж, эмийн түүхий эд бэлтгэдэг үйл явцтай танилцлаа.



Такламаканы цөлийн гуравдугаар форум нь Монгол орны цөлжилттэй тэмцэж буй туршлагыг дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн эрдэмтэн, судлаачидад таниулах, бусад

орны туршлагыг судлах, харилцан сайжруулах арга замыг хэлэлцэх зэрэг ихээхэн ач холбогдолтой форум болсныг онцлон тэмдэглэж байна.